



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

06.08 - 06.12



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд сүүлийн 3 сарын хамгийн их уналтыг үзүүлээ. Зах зээлийн үнэлгээ ихтэй компаниудын хувьцаа хамгийн их уналттай байлаа. S&P500 индексийн голлох 2 салбар болох эрчим хүч болон санхүүгийн салбар хамгийн бууралттай байсан бол хурдацтай өсөлттэй мэдээллийн технологийн салбар хамгийн бага бууралттай байлаа.

Нью-Йорк болон бусад эдийн засгийн хүндхэн байдалд ороод байсан бүс нутгууд эргэн нээгдэж эхэлж байгаатай холбоотой энэ долоо хоногийн эхээр жижиглэнгийн худалдаа болон аялал жуулчлалын салбарт өсөлттэй байсан. Цагаан ордны ахлах зөвлөх Кевин Хассетт дахин эдийн засгийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх магадлал бараг 100% байгаа гэж мэдэгдсэн ба үүнээс үүдэн S&P500 индекс өнгөрсөн жилийн мөн үеэс өндөр түвшинд хүрсэн бол технологийн компаниудын илүүтэйгээр агуулдаг Nasdaq Composite индекс бүх цаг үеийн хамгийн дээд хэмжээндээ хүрсэн байна.

Гэхдээ долоо хоногийн дундаас эхлэн нөхцөл байдал муудаж эхэлсэн. Лхагва гарагт болсон Холбооны Нөөцийн Сангийн мөнгөний бодлогын хорооны уулзалтын үр дүнд ойрын хугацаанд хүүгийн түвшин бага байх ба ямар нэг нэмэлт эдийн засгийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэхгүй гэсэн шийдвэр гаргасан байна.

Европ: Коронавирусийн 2 дахь давлагаа явагдаж, эдийн засгийн сэргэлт удааширч магадгүй гэсэн болгоомжлолоос үүдэн Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд мөн уналттай байлаа. STOXX Europe 600 индекс 4.99%-аар, Xetra DAX индекс 6.13%-аар, CAC 40 индекс 6.05%-аар FTSE MIB индекс 5.77%-аар тус тус буурсан байна.

Их Британи улс 03-р сараас эхлэн коронавирусээс шалтгаалан бүтэн сарын турш хөл хорионд байснаас үүдэн 04-р сард дотоодын нийт бүтээгдэхүүн 20.4%-аар буурсныг албаны эх сурвалжууд мэдээллээ. Өмнө жилийн мөн үетэй харьцуулахад эдийн засаг нь 24.5%-аар буурсан байна.

Япон: Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай хаагдлаа. Nikkei 225 индекс 558 пункт буюу 2.4% -аар буурч 22,305.48 нэгжид хүрсэн нь өмнө жилийн мөн үетэй харьцуулахад 5.7%-аар бага байна. Япон улсын хөрөнгийн зах зээлийн үндсэн индексүүд болох TOPIX индексүүд ижил хэмжээгээр буурсан байна. Баасан гарагт ам.доллартой харьцах иений ханш чангарсан бөгөөд ойролцоогоор 1 ам.доллар 107 иентэй тэнцэж байна.

БНХАУ: Дэлхийн эдийн засаг нөхцөл байдал болон зээлийн үзүүлэлтүүд сул байгаатай холбоотой БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт уналттай байв. Зах зээлийн үнэлгээ ихтэй компаниудаас бүрдэх CSI 300 индекс өмнөх долоо хоногийн түвшнээсээ өөрчлөгдөөгүй бол Shanghai Composite индекс 0.4% буурсан байна. Инфляцын түвшин засгийн газрын зорилтот түвшнээс доогуур байгаагаас шалтгаалан 10 жилийн хугацаатай БНХАУ-ын засгийн газрын бондын өгөөж буурсан байна.

БНХАУ-ын ерөнхий зээлийн хэмжээг илтгэдэг нийгмийн санхүүжилтийн түвшин өмнөх оны мөн үеэс 12.5% өссөн байгаа ч ихэнх хэсэг нь Засгийн газрын өрийн огцом өсөлттэй холбоотой байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,072.38	-0.87% ▼
Dow Jones	АНУ	25,650.54	-5.39% ▼
S&P 500	АНУ	3,041.31	-4.78% ▼
Nasdaq	АНУ	9,588.81	-2.30% ▼
S&P/TSX	Канад	15,256.57	-3.77% ▼
FTSE 100	Их Британи	6,105.18	-5.85% ▼
S&P/ASX 200	Австрали	5,847.80	-2.52% ▼
Nikkei 225	Япон	22,305.48	-2.44% ▼
Hang Seng	Хонг Конг	24,301.38	-1.89% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	107.52
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	99.78
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	99.60
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	104.49
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	100.52
DBM' 2023	USD	7.250%	96.50
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	87.41

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.195	0.02 ▲
Libor 3M	0.321	0.01 ▲
Libor 6M	0.432	-0.05 ▼
Libor 1YR	0.593	-0.04 ▼
US 2YR Bond	0.181	-0.02 ▼
US 3YR Bond	0.206	-0.07 ▼
US 5YR Bond	0.304	-0.16 ▼
US 10YR Bond	0.664	-0.23 ▼

Валютын ханш	2020.06.12	Өөрчлөлт
USD	2,813.22	0.13% ▲
CNY	397.56	0.75% ▲
EUR	3,186.11	1.23% ▲
RUB	40.38	-0.83% ▼
KRW	2.34	1.30% ▲
JPY	26.25	1.90% ▲
CAD	2,074.34	-0.21% ▼

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,730.75	0.03% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	17.49	-2.09% ▼
Зэс	USD/lb.	261.85	7.96% ▲
Нүүрс	USD/MT	53.98	-2.42% ▼
WTI газрын тос	USD/bbl.	36.26	2.17% ▲
Brent газрын тос	USD/bbl.	38.73	9.62% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	1.73	-6.49% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020. IV	4.7%
Бодлогын хүү	2020. IV	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020. IV	9.87%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020. IV	11.32%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020. IV	4.57%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020. IV	17.06%
Зээлийн дундаж хүү /валют/	2020. IV	10.36%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 49 компанийн 180.2 сая төгрөгийн 2,050,051 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Стандарт ноос” /ALI/ компанийн хувьцаа 14.58%-аар буюу хамгийн ихээр өсөж 275.00 төгрөг хүрч хаагдсан бол “Баянгол зочид буудал” /BNG/ компанийн хувьцаа 21.21%-аар буурч 26,000.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 2,006 ширхэг үнэт цаас 203.3 сая төгрөгөөр арилжаалагджээ.

06-р сарын 12-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,443.9 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 16,072.37 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.87%-аар буурсан байна.



Зах зээлийн тойм		Дүн (сая.төг)
Арилжигдсан үнийн дүн		383.5
Зах зээлийн үнэлгээ		2,443,873.8
Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,072.38	-0.87% ▼
MSE I индекс	7,969.51	-0.41% ▼
MSE II индекс	7,303.69	0.28% ▲
Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Лэндмн ББСБ	1,373,065	42,551,222
АПУ	77,338	41,883,673
Түмэн шувуут	95,051	12,244,787
Говь	56,019	10,739,986
Монос хүнс	131,910	8,569,443
Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Стандарт ноос	275.00	14.58% ▲
Хар хорум пропертийс	372.00	12.73% ▲
Махимпекс	2,650.00	10.19% ▲
Лэндмн ББСБ	32.06	6.26% ▲
Монос хүнс	68.44	3.70% ▲
Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Баянгол зочид буудал	26,000.00	-21.21% ▼
Шивээ овоо	1,625.00	-14.47% ▼
Өндөрхаан	1,200.00	-13.67% ▼
Мерекс	13.50	-12.90% ▼
Нако түлш	30.00	-11.76% ▼
Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК		Дүн (төг)
Мирэ Эссет Секьюритис Монгол		429,289,768
БиДиСек		76,342,115
Бумбат-Алтай		30,261,381
Ард секюритиз		25,975,751
Райнос инвестмент ҮЦК		25,324,319
Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	541.55	576,308
Таван толгой	5,500.00	289,659
МИК холдинг	12,650.00	261,973
Инвескор ББСБ	2,500.00	179,320
Говь	191.56	149,438

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-16/10/20-A0342-13.91	2,006	203,338,190	101,200	101,530	156	13.910%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.08.31-НИЙ ДОТОР
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.30-НЫ ДОТОР
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НЫ ӨДӨР
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.30-НЫ ДОТОР
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	715.9	1,000.0	139.7%	35.0	2020.04.07	2020.04.30-НЫ ДОТОР
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.24-НЫ ӨДӨР
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТҮР БҮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БҮК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.03.15-ААС
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.06.30-НЫ ДОТОР
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAH	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.01-НИЙ ДОТОР
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.05.01-ААС 2020.05.15-НЫ ХООРОНД
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.08.01-НЫ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.01-ЭЭС
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.05.31-НИЙ ДОТОР
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ



Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 06-р сарын 10-ны өдрийн 482 тоот тогтоолоор “Лэндмн ББСБ” ХК-ийн хувьцаагаар баталгаажсан 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нэг жилийн хугацаатай, жилийн 17%-ийн хүүтэй, нийт 5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 50,000 ширхэг өрийн хэрэгслийг бүртгэж, нийтэд санал болгон арилжаалахыг зөвшөөрсөн байна.

“Лэнд Бонд”-ын үндсэн андеррайтераар “Ард Капитал ҮЦК” ХХК, туслах андеррайтераар “Мирэ Эссэт Секьюритис Монгол ҮЦК” ХХК ажиллаж байгаа бөгөөд үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалгыг 2020 оны 06-р сарын 15-аас 06-р сарын 18-ны өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд, 6-р сарын 19-ний өдөр 10:00-15:00 цагийн хооронд авахаар боллоо.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /MSE:ERDN, TSE:ERD/ ХК-аас ирүүлсэн мэдээлэл

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /MSE:ERDN, TSE:ERD/ ХК нь Хөндий алтны төслийн хараат бус Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээг Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкнаас тавьдаг Гүйцэтгэлийн шаардлагын даруу Sustainability East Asia LLC, Ramboll Australia Pty Ramboll болон Eco Trade LLC зэрэг компаниудтай хамтран боловсруулж дууссан тухай мэдэгдлийг Монголын хөрөнгийн биржид 2020 оны 06-р сарын 09-ний өдөр ирүүллээ.

Тус мэдэгдэлд дурдсанаар Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Нарийвчилсан Үнэлгээний олон нийтийн хэлэлцүүлгийг 2020 оны дундуур хийхээр төлөвлөсөн бөгөөд хэлэлцүүлгийн дараа Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Нарийвчилсан Үнэлгээг батлуулахаар Монголын Улсын Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яаманд хүргүүлэх аж.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /MSE:ERDN, TSE:ERD/ ХК-аас ирүүлсэн мэдээлэл

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /MSE:ERDN, TSE:ERD/ ХК нь Баян Хөндий төслийн эцсийн ТЭЗҮ-ийг эцэслэх шатанд орж байгаатай зэрэгцэн бүтээн байгуулалт, олборлолтын үйл ажиллагаанд бэлтгэхээс гадна Баян Хөндий ил уурхайн нөөцийг өмнө зүгт тэлэх боломж, шинээр өндөр агуулга бүхий газрын дөт гүнд Хар Морь талбайг нээн илрүүлж, Алтан Нар ордын Нээлтийн Бүсэд орших өндөр агуулга бүхий талбайг тэлж, шинэ алтны дүүргийн боломжуудыг нарийвчлан судлах ажлуудыг гүйцэтгэхээр 06-р сараас эхлүүлсэн 2-р улирлын хээрийн ажил болон техникийн судалгааны тухай мэдээллийг танилцуулсан байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Улсын их дэлгүүр” /MSE:UID/ ХК-д үүссэн онцгой нөхцөл байдалтай холбогдуулан зөвлөмж хүргүүллээ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн зүгээс 2020 оны 06-р сарын 07-ны өдөр “Улсын их дэлгүүр” /MSE:UID/ ХК-ийн барилгад гал түймрийн аюул нүүрлэж, томоохон гарз хохирол тохиолдсонд харамсаж байгаагаа илэрхийлэхийн хамт үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах чиглэлээр авбал зохих арга хэмжээний талаар зөвлөмж хүргүүллээ.

Бүртгэлтэй хувьцаат компани нь ҮЦЗЗТХ болон Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”, МХБ-ийн Бүртгэлийн гэрээнд заасны дагуу хувьцааны үнэ ханшид нөлөөлөхүйц аливаа онцгой нөхцөл байдлын үйл явц, хохирлын хэмжээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хувьцаа эзэмшигчдэд тухай бүрд нь шуурхай мэдээлэх үүрэгтэйг нийт үнэт цаас гаргагчид анхааралдаа авахыг хүсье.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Бодь даатгал” /MSE:BODI/ ХК-ийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа 2020 оны 06-р сарын 15-аас эхэлнэ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2020 оны 06-р сарын 11-ний өдрийн 1/2494 тоот албан тушаалаар “Бодь даатгал” /MSE:BODI/ ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцсон бөгөөд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг 2020 оны 06-р сарын 15-ны өдрөөс эхлүүлэх зөвшөөрлийг олгосон байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ



ОНЦЛОХ МЭДЭЭ

Оны эхний таван сард улсын төсөв урьдчилсан гүйцэтгэлээр 1.6 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа. Цар тахлаас үүдсэн хилийн хязгаарлалт, өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаатай холбоотойгоор уул уурхайн экспортын орлого огцом буурсан саруудад төсвийн нөхцөл байдал огцом муудлаа. 2016 онд улсын төсөв 3.6 их наяд төгрөгийн алдагдалтай гарч байх үед төсөв оны эхний таван сард ийм өндөр хэмжээний алдагдалтай гарч байгаагүй юм.

Эх сурвалж: BloombergTV.mn



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Банкнуд 500 тэрбум орчим төгрөгийн ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах хүсэлтийг шийдвэрлэсэн гэж Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн мэдээллээ. Мөн шинэ төрлийн "коронавирус"-ийн нөлөөгөөр эргэн төлөлт нь хүндрэлд орсон 37 мянга гаруй зээлд бүтцийн өөрчлөлт хийжээ. Монголбанкнаас гаргаж байгаа санхүүжилттэй тэнцүү хэмжээгээр арилжааны банкнуд өөрийн эх үүсвэрээр ипотекийн зээлийг санхүүжүүлэх боломж бүрдэж байгааг Төв банк онцолсон юм. Тухайлбал: тавдугаар сард ипотекийн зээлд Монголбанк, арилжааны банкнаас тус бүр 25 тэрбум төгрөг буюу нийт 50 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор ажиллаж байна. Энэ оны үлдсэн саруудад Монголбанкнаас 20-25 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийн санхүүжилтийг сар бүр олгох ажээ.

Эх сурвалж: Монголбанк

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ урт хугацаанд хэвээр үлдээхээ мэдэгдэж, мөн АНУ-ын зарим мужид "COVID-19" дахин дэгдэх эрсдэл бий болсон нь алтны фьючерс үнэ өсөхөд түлхэц боллоо. Пүрэв гарагийн арилжаагаар алтны фьючерс үнэ 1.1 хувиар өсөж, унц тутамдаа 1739 ам.доллар болсон нь сүүлийн долоо хоногийн дээд түвшинд тооцогдож байна.

Цар тахлын хүндрэлээс эдийн засгаа гаргахын тулд Холбооны Нөөцийн банк "Шаардлагатай бүхий л арга хэмжээг цаг тухайд нь шуурхай хэрэгжүүлэх үүрэгтэй" гэж Жером Пауэлл мэдэгджээ. Түүнчлэн бодлогын хүүгийн төлөв 2022 оныг дуустал "тэг" орчимд байна гэж дийлэнх шинжээчид таамаглаж байна.

Эх сурвалж: BloombergTV.mn



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.